



**П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ
УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ**

Ард Аюушийн гудамж 1а, 5 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16081
Утас: (976) 7700 0304,

Цахим шуудан: tsch@shastinhospital.mn
Цахим хуудас: www.shastinhospital.mn

2024.12.17. № 01/1335

танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗАРТ**

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд тус
эмнэлгээс хэрэгжүүлсэн 2024 оны хэрэгжилтийн
тайланг нэгтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 11 хуудастай.

ЗАХИРАЛ, АНАГААХ УХААНЫ
ДОКТОР Ц.ТӨМӨР-ОЧИР



160810401559

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

2024 оны хэрэгжилт

Зорилт	Арга хэмжээ	Хүрсэн түвшин, үр дүн/
2.1.Чинээлэг Монгол хүн		
2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого		
2.1.1.14.	Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлнэ.	ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
		2024 оны 12 сарын байдлаар андрологи 2985, урологийн үзлэгт 3077 эрэгтэй тус тус хамрагдсан байна. Амбулаторийн урологи-андрологийн нийт үзлэгийн 61% нь эрэгтэйчүүд байна. - Эрт илрүүлэгийн үзлэгт нийт 131 эрэгтэй ажилтан хамрагдсан. Үүнээс АГ- 47 (35.8 %), Элэгний В болон С вирусын шалтгаант архаг үрэвсэл-17 (12.9 %), элэгний хатуурал-3 (2.2 %) тус тус илэрсэн. Мөн чихрийн шижин эмгэгтэй эрэгтэй 5 ажилтан дотоод шүүрлийн эмчийн байнгын хяналтанд,1 ажилтан элэгний цирроз, 2 ажилтан үеийн эмгэгийн улмаас групп-д орж, ажлын байрны зохицуулалт хийж ажилласан. - Эмч мэргэжилтний сарын аяны зорилтот үйл ажиллагааны хүрээнд эмнэлгийн эрэгтэй 65 эмч, мэргэжилтэнд үзлэг, оношилгоо хийж ЭЛЛ-тэй хамтарч түрүү булчирхайн үрэвсэл илрүүлэх зорилгоор өвөрмөц болон өвөрмөц бүс үүсгэгч илрүүлэх РСР болон бактeрлоги шинжилгээ хийж, зөвлөгөө өгсөн. - Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран, “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгээр 200 гаруй эрэгтэйчүүдэд үзлэг хийж, зөвлөгөө өгч ажилласан. - Шинэ эрин ЕБСургуулийн 9 дүгээр ангийн 51, Үй Цай сургуулийн 69 өсөөр насны хөвгүүдэд “Хөвгүүдийн шилжилтийн нас ба бэлгийн бойжилт”, “Эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх”, 10 сард Техник технологийн их сургуулийн 130 гаруй оюутанд “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол” сэдвээр хичээл сургалтыг тус тус зохион байгуулсан. - Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгээр 1168 эрэгтэйчүүд болон Урологийн кабинеттаар үйлчлүүлж байгаа байнгын гуурстай үйлчлүүлэгчид зориулж “Шээсний шинжилгээ зөв авах” сэдэвт гарын авлага боловсруулж , үйлчлүүлэгчдэд түгээсэн.

		Эмнэлгийн телеграм хуудсанд эмч, ажилчдад "Томуу томуу төст өвчнөөс сэргийлье", "Таргалалтаас сэргийлье", "Даралт ихсэх өвчнөөс хэрхэн сэргийлэх вэ?, Идэвхитэй хөдөлгөөн, харшилаас сэргийлье, "Ханасан өөх, тос, давсны хэрэглээг бууруулъя", "Дасгал хөдөлгөөний ач холбогдол", Унаж бэртэхээс сэргийлье, Хавдраас сэргийлье, "Идэвхитэй хөдөлгөөн хийцгээе", "Давсны зохистой хэрэглээ, нийгмийн эрүүл мэндийн хуулийн сурталчилгаа, "Хүнсний зөв зохистой хэрэглээ", "Дэлгэцийн донтголт", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэгт орчин бүрдүүлэх. Дэлхийн эрүүл мэндийн өдрийн сурталчилгаа, "Тамхины хор нөлөө", "Амны хөндийн эрүүл ахуй" "Шүд", "Сэтгэцийн эрүүл мэнд", Зүрхээ хайрлая сэдэвт 158 зөвлөмжийг телеграм хуудсаар сурталчилсан.
	Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэйгөөс бусад ажлын байранд ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна.	Тус эмнэлэгт өндөр насны тэтгэвэр тогтоолгон ажиллаж байгаа ахмад настан 19 байгаа бөгөөд нийт ажлын байрны 2,2%-ийг эзэлж байна.
2.3. Эрүүл Монгол хүн		
2.3.1.Нийгмийн эрүүл мэнд		
2.3.1.1.	Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379, Эмнэлгийн захирлын 2024 оны А/04 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган БГД-ийн 15, 17 дугаар хороо, СХД-ийн Баянхошуу, Тогтойтын бүсийн 1, 3, 20, 25, 32, 34, 42 дугаар хороод, өөрсдийн хүсэлтээр харьяаллын бүс 18 наснаас дээш насны иргэдийг насны багцаар эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд хамруулан хавдар, хавдрын урьдал, халдварт бус өвчинг оношлох, эмчлэх, хяналтад авах, илгээх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. - 2024 оны 11 дугаар сарын байдлаар тус эмнэлэгт эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд нийт 20909 иргэн хамрагдсан байгаагаас 2024 онд нийт 4030 иргэн хамрагдаж, үүнээс хүйсийн хувьд 61.3% нь эмэгтэйчүүд, насны хувьд 31-45 насныхан 38.5 хувийг эзэлж байна. Харьяалалын хувьд Сонгинохайрхан дүүрэг 12818 (64.4%), Баянгол дүүрэг 2342 (11.8%), харьяалалын бүс 4850 (24.2%) иргэн хамрагдсан. - ЭМС-ын 2024 оны А/71, А/150 дугаар тушаалуудын хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 08-аас 10 дугаар сарын 24-ний хооронд алслагдсан орон нутаг, сумдын иргэдийг эрт илрүүлгийн үзлэг оношилгоонд хамруулах зорилгоор оношилгоо эмчилгээний аппарат, багаж хэрэгслээр иж бүрэн тоногдосон "Нүүдлийн эмнэлэг"-ийн зориулалттай том оврын автомашинаар Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн алслагдсан хороо, Баян-Өлгий, Ховд, Завхан, Увс, Говь-Алтай,

		Хэнтий аймгийн 28 сумыг хамарсан нийт 7 чиглэлд зурх, мэдэрл, бөөр, уушги, эмнэлгэйн лаборатори, дүрс оношилгоо, дуран, эмэгтэйчүүдийн төрөлжсөн мэргэшлийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, мэдээллийн технологийн бүрэлдэхүүнтэй 7 багийн нийт 93 мэргэжилтэн ажилласан. - Энэхүү эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд нийт 6808 иргэнийг хамруулж, 51283 лабораторийн шинжилгээ, 31248 багажийн шинжилгээнд хамруулсан. - Илэрсэн өвчлөлд бөөр, дотоод шүүрлийн өвчлөл 29%, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл 22%, зүрх судасны өвчлөл 17.9%, бусад эрхтэн тогтолцооны өвчлөл 7.4%-ийг эзлэж байна. - Хавдрын 53 шинэ тохиолдол илрүүлснээс ходоодны хавдар 5, элэгний хавдрын 6 тохиолдлыг мэс заслын эмчилгээнд хамруулсан. - Шинээр оношлогдсон өвчлөл, хавдрын урьдал болон сэжигтэй тохиолдлыг харьяа эрүүл мэндийн байгууллагаар нь дамжуулан шаардлагатай онош тодруулах шинжилгээнд хамруулах, эмчлэх эрүүлжүүлэх, хяналтанд авах арга хэмжээг авч ажилласан. - Тус эмнэлгийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн хамрагдалт өмнөх оныхоос 34.1%-иар нэмэгдсэн. - 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Дэлхийн эрүүл мэндийн тэмдэглэлт 9 өдрийн үйл ажиллагааг 2500 гаруй эмч, эмнэлгийн ажилтан, иргэд үйлчлүүлэгчийн хүрээнд зохион байгуулж, 27 төрлийн 3000 орчим гарын авлага, 17 төрлийн сурталчилгааны самбар постер хэвлэн сурталчилсан. Зөвлөх поликлиникээр үйлчлүүлсэн 8530 гаруй иргэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 4 чиглэлээр 28 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. - Эмнэлгийн албан ёсны Фейсбүүк хуудсаар дамжуулан иргэд, олон нийт, тус эмнэлгээр үйлчлүүлэгчдэд өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар 28 видео зөвлөгөө, эмнэлгийн зөвлөх зэргийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтний 36 зөвлөгөөг видео болон постер хэлбэрээр байршуулж олон нийтэд хүргэж ажилласан. 2024 онд "Цусны даралт ихсэлтийн эсрэг аян"-ыг зүүн бүсийн 4 аймагт зохион байгуулах Хамтран ажиллах 330-004/68 тоот гэрээг байгуулж, санхүүжүүлэгч Хаан банк, хамтран хэрэгжүүлэгч УТЭЗ, НЭМҮТ, МҮОНРТ хамтран "Цусны даралт ихсэлтийн эсрэг аян-2024"-ыг Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр аймагт 7,8 сард хэрэгжүүлж, 16780 гаруй иргэдийг аяны үйл ажиллагаанд хамруулсан. Үйл ажиллагаагаар цусны даралт ихсэлтийн эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх үнэлгээг 40-өөс доош насны, зурх судасны өвчнөөр (ЗСӨ) ойрын 10 жилд өвдөх эрсдлийг тогтоох үнэлгээг 40-өөс дээш насныханд, бие бялдрын бүрдмэл үзлэг, эрүүл амьдралын хэв маяг сургалт, зөвлөгөө зэрэг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, төрөлжсөн нарийн мэргэжлийн үзлэг оношилгоог 4180 гаруй хүнд хийж, зөвлөгөө өгч, орон нутгийн 120 эмч
--	--	---

		мэргэжилтэнд "Цусны даралт ихсэлт түүний эрсдэлт хүчин зүйл, хүндрэлээс сэргийлэх нь" 1,5 кредит сургалтыг зохион байгуулж ажилласан. МҮОНРТ, Eagle TV, NTV, TV9 төлөвизээр 8, Ikon.mn, Gogo.mn, News.mn зэрэг 10 вэбсайтаар давхардсан тоогоор, нийт 28 удаагийн мэдээ мэдээлэл хийж сурталчилсан. 2024 оны 06 сарын 04-ний өдөр Нийгмийн эрүүл мэндийн хууль батлагдсантай холбоотой иргэд үйлчлүүлэгчид "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулсан. Өдөрлөгт нийт 22 тасаг нэгж оролцож иргэд, үйлчлүүлэгчдэд Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх, авлигын эсрэг таны оролцоо сургалт мэдээллийн үйл ажиллагаа явуулж, эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмж өгөх, ясны сийрэгжилт, биеийн жингийн индекс, цусны даралт, чихрийн шижинг тодорхойлж, харвалт, зүрхний шигдээсийн үеийн сэргээн засах эмчилгээ, уламжлалт засал эмчилгээ, мэс заслын дараах үеийн сувилгаа, үйлчлүүлэгч ард иргэд оношлогоо шинжилгээнд орох үеийн бэлтгэл, эмийн зохистой хэрэглээ, зөв хооллолтын чиглэлээр зөвлөгөө зөвлөмжийг давхардсан тоогоор 750 гаруй хүнд өгч, эрүүл мэндийн боловсрол олгох 44 төрлийн 1490 гарын авлага, зуралт ном хэлбэрээр эрүүл мэндийн зөвлөмж материалыг бэлтгэн түгээсэн. 2024 оны 9 сарын байдлаар 7868 хүнд цусны даралт ихсэлтийн эрсдлийн үнэлгээ хийж, архи тамхи, хооллолт, дасгал хөдөлгөөн, илүүдэл жин таргалалтын зэргийг тодорхойлж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.
2.3.1.2.	Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжинэ.	- Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран, "Эрүүл Монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгээр 200 гаруй эрэгтэйчүүдэд үзлэг хийж, зөвлөгөө өгч ажилласан. 09 сарын 30-ны өдөр Зүрх судасны үндэсний төвийн эмч нар ард иргэдэд зориулсан онлайн сургалтыг зохион байгуулж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Өдөрлөгт зориулж ханын самбар, гарын авлага 3 төрөл 700ш хэвлүүлж, МҮОНРТ-ийн 11 цагийн мэдээ, Цагийн хурд мэдээллийн хөтөлбөр, эмнэлгийн цахим хуудсаар олон нийтэд үйл ажиллагааг сурталчилсан. Эмнэлгээр үйлчлүүлэх үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, тусламж, үйлчилгээг тэдний хууль ёсны хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй авах боломжоор хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Нийгмийн эрүүл мэндийн албыг 2024 оны А/176 дугаар тушаалаар байгуулсан. Нийгмийн эрүүл мэндийн алба нь иргэд үйлчлүүлэгч болон эмч ажилчиддаа чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сэтгэл зүй, хоол зүй шим тэжээл судлалын үйл ажиллагааг явуулж, мэдээлэл сургалт, судалгааны чиглэлд түлхүү анхаарч байна. Мөн нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг ажлын байранд нь тасралтгүй сургах,
2.3.1.3.	"Эрүүл шүд", "Хорт хавдраас сэргийлэх, хянах", зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.	
2.3.1.4.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх дэд төвийг бүс бүрд байгуулна.	

		мэргэшүүлэх, чадавхжуулах улмаар тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, бодит үр дүнт гаргахаар зорьж байна.
2.3.2.Эмнэлтийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж		
2.3.2.1.	Эмнэлтийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв/.	- Зүрх судасны үндэсний төвийг барьж байгуулахад хөрөнгө оруулалтын дэмжлэг, гуравдагч эх үүсвэрийн асуудлын талаар Европын хөрөнгө оруулалтын банк зэрэг байгууллагуудтай хөрөнгө оруулалтын боломжийг судалж барилгын асуудлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 1а/5814 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. - ЗСҮТөвийн барилгын ажил 2023 онд баригдаж эхлэхээр Засгийн газрын зайлшгүй хэрэгжүүлэх том төслүүдийн жагсаалтад багтан төлөвлөгдсөн. - Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад Зүрх судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний төсөв (УТ2402002254) болох 2.252.1 тэрбум төгрөгийн төсөв тусган батлуулсан. 2024 онд Люксембургийн Их гүнт улсын Гадаад хэргийн яамнаас Зүрх судасны үндэсний төвийг төрөлжүүлэн байгуулахад 19 сая еврогийн буцалтгүй тусламж олгохыг албан ёсоор мэдэгдсэн. - Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас хамтран оролцох шийдвэрээ гаргаж Хөндлөнгийн үнэлгээний зөвлөх багийг 2024.10.25-29-ны өдрүүдэд УТТЭ-д ажиллуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангасан.
2.3.2.2.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, эмнэлгийн наралттай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	- ЭМС-ын 2021 оны А/814, Эмнэлгийн захирлын 2022 оны А/306 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд наралттай тусламж, үйлчилгээг үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж ажилласан. 2024 оны 11 сарын байдлаар тус эмнэлэг 21701 иргэнд наралттай тусламж үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.8%-иар өссөн. 2023 оны мөн үеийнхээс хөх эрэмбийн тусламж 0,6%-иар, улаан эрэмбийн тусламж, 0,9%-иар, ногоон эрэмбийн тусламж 1,1%-иар тус тус буурсан бол шар эрэмбэ 0,7%-иар, цагаан эрэмбэ 0,7%-иар тус тус өссөн. - Амь тэнссэн үеийн амилуулах ерөөгөөр нийт 218 эмчлүүлэгч үйлчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1,3%-аар буурсан, үүнээс зохиомол амьсгалын алпаратанд авсан нийт 75 буюу 0,8%-аар өссөн байна. - Гаднаас зүрх зогсож орж ирэн, амилуулах лавшруулсан тусламж авсан 19 (0,6%-иар буурсан) тохиолдлоос цусны эргэлт сэргэж тасалт шилжиж хэвтсэн 7 тохиолдол, цус эргэлт сэргээгүй нас барсан 12 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 0,6% буурсан. - Эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээг олон улсын жишигт ойртуулан чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгын хүрээнд эмнэлгийн нас баралт, хоног болоогүй нас баралтыг бууруулах зорилт тавьж ажилласан.



		• 2024 оны 11 дүгээр сарын байдлаар дотрын эрчимт эмчилгээнд 391 эмчлүүлэгч, тархины харвалтын эрчимт эмчилгээнд 580 эмчлүүлэгч, зүрхний шигдээсийн эрчимт эмчилгээнд 824 эмчлүүлэгчийг тус тус хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлсэн. • Эрчимт эмчилгээнд хэвтэн эмчлүүлэгсдийн тоо харвалтын эрчимт эмчилгээ 11.9%, зүрхний шигдээсийн эрчимт эмчилгээ 6.5% тус тус өссөн байгаа бол ерөнхий дотрын эрчимт эмчилгээ 11.9%-иар өмнөх оны мөн үеийнхээс буурсан үзүүлэлттэй байна. • 2024 онд амилуулах суурь тусламж үйлчилгээг багаараа стандарт удирдамжийн дагуу түргэн шуурхай үзүүлэх, амь тэнссэн нааралтай үед багаар ажиллах чадаар, хандлагыг төлөвшүүлж дадлагажуулах зорилгоор “Амилуулах суурь тусламж үзүүлэхэд сувилагч тусгай мэргэжилтний оролцоо” сэдэвт ур чадварын VIII тэмцээнийг 23 тасаг, албадын 0-3 жил ажиллаж байгаа шинэ сувилагч, тусгай мэргэжилтнүүдээс бүрдсэн 6 багийн дунд зохион байгуулсан. Энэ удаагийн тэмцээнд нааралтай тусламжид тулгамддаг цочмог эмгэгийн үед үзүүлэх тусламж үйлчилгээ, нааралтай тусламжийн үед түгээмэл хэрэглэгддэг эм тарианы үйлчилгэл, ЭМ-ийн сайдын болон ЭЗ-ын тушаал, журмын тухай мэдлэгийг үнэлэх тохиолдол дээр суурилсан сорилгийг зохион байгуулснаар онцлогтой. QR кодоор хөгжөөн дэмжигч, оролцогчдын мэдлэгийг үнэлж, сэтгэл ханамжийн судалгаа бөглүүлсэн. Тэмцээний бүхий л үйл явцыг дэлгэцээр шууд дамжуулалт хийж нийт 160 гаруй эмч, резидент эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн оролцсон. • Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг лавлагаа шатлалын мэргэжил арга зүйгээр хангах зорилгот хөтөлбөрийн хүрээнд Жайкагийн сайн дурын байгууллагатай хамтран “Тархины харвалт, зүрхний шигдээс, нааралтай тусламж, эрчимт эмчилгээний үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний цогц шийдэл” сэдэвт онол дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Дорноговь аймгийн 14 сумын болон өрхийн эмнэлгийн 50 ахлах сувилагч, сувилагч мэргэжилтэн хамрагдсан.
2.3.2.3.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, зарцуулалтыг оновчтой болгон, иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад төлөх төлбөрийн хэмжээг бууруулна.	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн батлах тухай 06 дугаар тогтоолыг хэрэгжүүлснээр тус эмнэлгийн иргэн төлөх хамтын төлбөрийн орлого 2023 онтой харьцуулахад 30 хувиар буурсан.
2.3.2.4.	Маш цөөн хийгддэг, өндөр зардалтай тусламж, үйлчилгээг гадаад улсын эмнэлэгтэй хамтын гэрээ	МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан Эрүүл мэндийн тусламж,

байгуулж, тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.	Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэдийн эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллалаа. Эрүүл мэндийн сайдын Өндөр хөгжилтэй улсад суралцуулах 2022-2025 оны чиглэлийн дагуу оны эхний хагас жилийн байдлаар 8 улсад 10 чиглэлээр 55 эмч, сувилагч урт болон богино хугацааны сургалтад хамрагдан мэдлэг чадавгаа дээшлүүлсэн байна. Тус эмнэлгийн мэдрэлийн мэс заслын чиглэлээр тархи, нугасны гүний байрлалтай хавдрын мэс заслын эмчилгээгээр 2 эмч 1 сувилагч 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн Турк улсад сургалтад хамрагдаж байна. Тус эмнэлэг нь 14 улсын 47 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. 2024 оны 8-10 сард нийт 4 эмчийг төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх урт хугацааны гадаад сургалтанд хамруулж байна. Үүнд: • БНСУ-ын Сөүл хотын Йонсей их сургуульд "Зүрхний титэм судасны судасан дотуурх эмчилгээ, захын судасны судасан дотуурх эмчилгээ, хавхлагын эмгэгийн үеийн судасан дотуурх эмчилгээ"-ний чиглэл • БНХАУ-ын Шанхай хотын Рүйжин их сургуулийн эмнэлэгт зүрх судасны мэс заслын чиглэл • Португал улсын Лисбон хотод зохион байгуулагдсан 38 дахь удаагийн Европын Зүрх, Цээжний хөндийн мэс засалч нарын нийгэмлэгийн конгресс /EACTS/ • Люксембургийн Их Гүнт Улсын Зүрх судасны үндэсний төвд Зүрх судасны мэс заслын чиглэлд мэргэшүүлж байна. Гол судасны уруудах хэсгийн аварга хэмжээтэй хуурамч цүлхэнг устгаж, өөрийн перикардаар гол судсыг нь нөхөн сэргээх мэс заслыг Монгол улсад анх удаа Францын Страссбургийн их сургуулийн зочин профессорын багтай хамтран амжилттай хийсэн. Зүүн этмэн доорх артерийн аварга цүлхэнтэй насанд хүрсэн эмчлүүлэгчид гүн хөргөлттэй тархины сонгомол эргэлтийн нөхцөлд аварга цүлхэнг устгаж, гол судасны нумыг бүрэн солих, зүүн этмэн доорх артерийг зүүн гүрээний артеритай холбох мэс заслын маш ховор тохиолдлыг Монгол улсад анх удаа Францын Страссбургийн их сургуулийн зочин профессорын багтай амжилттай хийсэн. Хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийн баг Францын зочин профессорын багтай хамтран том судасны солбисон байрлал /TGA-L/ оноштой нарайд анх удаа төгс мэс засал амжилттай хийсэн. Мөн ажлын байран дээрх чадавхжуулах сургалтыг гадаадын зочин профессоруудтай хамтран хэрэгжүүлдэг бөгөөд БНСУ-ын Сөүл хотын Ча Бундан эмнэлгийн Зүрх судасны мэс заслын зөвлөх эмч Вупинг Шыи Chang эмч нь 2024.09.08-14-ний хооронд, Люксембургийн Зүрх судасны төвийн баг 2024.08.24 – 2024.09.07-ны хооронд ирж, дотоодын зүрхний мэс заслын багтай хамтран нийт 16 өвчтөнд үзлэг зөвлөгөө өгч, 2 хүүхэд 8 насанд хүрэгчдэд
--	---

		буюу нийт 10 хүнд хэлбэрийн мэс засал хийсэн. Тус багт ажилласан Хүүхдийн зүрх судасны мэс заслын Sabine эмч зүрхний хавхлагийн мэс заслын онцлог, мэс засал эмчилгээний техник сэдэвт 3 удаагийн лекц сургалтыг зохион байгуулсан.
		Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн 45, гадаадын хөрөнгө оруулалттай эмнэлэг 9, амбулатори 200 орчим ажиллаж, 841 уламжлалт анагаах ухааны их эмч, 455 сувилагч анхан болон лавлагаа шатгалын тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд эдгээр эмнэлгүүдэд шаардлагатай эмнэлгүүн заавар, түгээмэл үйлдлийн стандарт, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, түүний нэхэмжлэлийн хяналтын шалгуур шинэчлэх ажлын хэсгүүдэд орж ажилласан.
2.3.2.5.	Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэн, экспортод гарах гарцыг нэмэгдүүлнэ.	Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлд дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин лавлагаа шатанд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг мэдрэлийн болон зүрхний чиглэлээр үзүүлж эрдмийн судалгаа, шинжилгээний чиглэлд тогтмол илтгэл хэлэлцүүлж үр дүнг тооцуулдаг. "Эмнэлгүй 2024" тусгай байр, "УАУ-ны Сайн туршлага" тэргүүн байр эзэлсэн.
		Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн инновацийн эмийн бүтээгдэхүүн болох Нейроваген, Асвааргал зэрэг эмийг эмнэлгүүн практикт хэрэглэж байна.
	Иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи төлөмөдийн, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.	2024 онд MпSardio програмд шинээр 14300 иргэний ба 3607 үзлэг бүртгэгдсэн. Нийт 37 алсын зайн хэлэлцүүлэг, зөвлөгөөн хийгдэж ажилласан. Мөн MпSardio програмд 508 эмч, мэргэжилтэн шинээр бүртгэгдэж, нийт 2229 системийн хэрэглэгчтэй болов.
2.3.2.6.		2024.10.23 өдрийн байдлаар нийт 16028 иргэнд Зүрх судасны эрсдэлийг тодорхойлж ажилласан.
		MпSardio програмд суурь шинэчлэлийн ажил хийгдэж дууссан ба зүрхний дутагдал, хэм алдагдал, хавхлагын эмгэг, төрөлхийн гажиг, судасны эмгэгийн чиглэлд үндэсний бүртгэл судалгааг эхлүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон.
2.3.2.7.	Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг олон улсын стандартын дагуу бүрдүүлж, их өгөгдөл үүсгэнэ.	Тус эмнэлэгт ашиглагдаж буй eHealth програм нь ХУР систем, Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгал, e-Baimt, NIEP зэрэг улсын хэмжээний томоохон системүүдтэй мэдээлэл солилцож байна. Энэ нь Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг олон улсын стандартын дагуу бүрдүүлж, их өгөгдөл үүсгэхэд тус эмнэлгийн хувьд бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Одоогийн байдлаар тус эмнэлэг дээрх амбулаторийн болон хэвтэн эмчлүүлсэн тусламж үйлчилгээний мэдээлэл нь ЭМДаатгалын сервер дээр шалгуур үзүүлэлтийн дагуу API сервис солилцон мэдээллээ илгээж байна.
2.3.2.8.	Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, ноголгоонд суурилсан	Орчин үеийн шинжлэх ухааны ноголгоонд тулгуурласан сэргээн засах чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлэх зорилгоор 2024 онд өдрийн сэргээн засах тусламж үйлчилгээ, хэвтүүлэн эмчлэх ортой сэргээн засах тусламж үйлчилгээг шинээр нээж, үйл ажиллагааг өргөжүүлсэн. Сэргээн засах төвөөр 56 нэр төрлийн сэргээн засах тусламж үйлчилгээг бүртгэлжүүлж, давхардсан тоогоор хөдөлгөөн засал эмчилгээнд

	тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.	4879, хөдөлмөр засал эмчилгээнд 3626, хэл засал эмчилгээнд 1512, зүрхний эмгэгийн сэргээн засах эмчилгээнд 952, бусад эмчилгээнд 2520 удаа хамрагдсан байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 1066 эмчлүүлэгчдэд 12129 удаагийн давтамжтай сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн. Үүнийг оношийн бүлгээр авч үзвэл: - Тархины харвалттай - 697 - Зүрхний шигдээстэй - 59 - Зүрхний архаг дутагдалтай - 9 - Нугасны гэмтэлтэй - 7 - Хүүхдийн тархины саатай - 0 - Хүүхдийн нугасны мэдрэлийн ёзоорыг тайрах мэс засалд орсон - 2 - Нурууны мэс засалд орсон - 40 - Хэл яриа, залгуурын алдагдалтай – 252 байна.
2.3.3.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хуртээмж		
2.3.3.1.	Олон улсын зохистой дадал, стандартыг бүрэн нэвтрүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эмийн импортыг бүрэн цахимжуулна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, төр хувийн хэвшлийн түншлэл" хэлэлцүүлэгт эмнэлгийн удирдлага, холбогдох албан тушаалтнууд оролцож, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, мөн түүнийг дагалдан гарах журмын төслүүдэд саналаа өгч ажилласан. Үүнд: 1. Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгож журам 2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтийн журмын төсөл, 3. Лабораторийн оношилгооны хэрэгслийн хяналт, эмнэлгийн хэрэгтлэгдэхүүнийг шинжлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжинд шалгалт баталгаажуулалт тохируулга хийх журам, арга аргачлалыг батлах тухай 4. Үлгэрчилсэн албан тушаалын тодорхойлолтод Эм зүйн албаны дарга, эмнэлзүйн эм зүйч, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны инженер-менежер, инженер, техникч нарын албан тушаалын тодорхойлолтод санал өгсөн.
2.3.3.2.	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг хянах лабораторийг үндэсний түвшинд бэхжүүлэх, дотоодын эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэж, экспортод гаргах боломжийг нэмэгдүүлнэ.	хамаарахгүй
2.3.3.3.	Эмийн худалдан авалтад үнийн хэлцэл хийх, олон улсын байгууллагаар дамжуулан худалдан авах, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас эм, эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авах тогтолцоог бүрдүүлнэ.	2024 оны эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, протезын 37,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 151 багц бүхий худалдан авах ажиллагааг ТХААГ-аар 100% гүйцэтгүүлж худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажилласан. Цахим дэлгүүрээс Ерөнхий гэрээгээр 70 удаагийн гэрээ байгуулан 107 нэр төрлийн эм, 32 нэр төрлийн нэг удаагийн хэрэгслийн худалдан авалт хийж ажиллаж байна.

		Эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаар дамжуулан худалдан авах. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас эм, эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авахаар Эрүүл мэндийн яамнаас харьяа байгууллагуудаас хавдрын хими эмчилгээний эмүүдэд санал авсан.
2.3.4.Эрүүл мэндийн салбарын хүний нөөц		
2.3.4.1.	Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх зорилгоор шинэ, дэвшилтэт технологи, арга, аргачлал нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, гадаадын ур чадвар бүхий мэргэжлийн багийг эх орондоо урьж, туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Гадаадын их дээд сургуулийн эмнэлэг хоорондын хамтын ажиллагааны хүрээнд гадаадын зочин профессорын багудтай хамтарсан ажлын байрны мэс засал сургалтыг багтагдсан төлөвлөгөөний дагуу нийт 11 улсын 13 байгууллагын 6 чиглэлийн зочин профессорын багийн 57 мэргэжилтэнг хүлээн авч хамтарсан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. - Хамтарсан багаар Монгол улсад хараахан бие даан хийх боломжгүй нарийн төвөгтэй, өндөр ур чадвар шаардсан нийт 242 мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлснээс, насанд хүрсэн 159, хүүхдийн 83 тохиолдолд мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлсэн. - Гадаад багтай хамтарсан мэс заслын тусламжаар нийт 3,188,222,340 төгрөгийн өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээг эх орондоо эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хийж гүйцэтгэн, эрүүл мэндийн эдийн засгийн гадаад руу чиглэсэн урсгалыг бууруулж ажилласан. Зочин профессорын багтай хамтарсан эмнэлзүйн үйл ажиллагаагаар Эрүүл мэндийн сайдын А/273 дугаар тушаалын жагсаалтын А1.2, В6-10 дугаарт багтсан нийт 6 төрлийн бүлэг өвчний оношилгоо эмчилгээний технологийг нутагшуулах чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулж ажилласан. - Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн, хуулрал, гол судасны хүнд хэлбэрийн нарийслын үеийн нээлттэй мэс заслын чиглэлээр ЭМС-ын 2024 оны А273 дугаар тушаалын жагсаалтын В8 дахь жагсаалтад заагдсан өвчлөлийн оношилгоо эмчилгээ нутагшуулах чиглэлээр ЭМС-ийн санаачлага, төрийн сангийн санхүүжилтээр 2 эмч, 2 сувилалгчийг багаар нь БНСУ-ын Ионсэй их сургуулийн эмнэлэгт 1 сарын хугацаатай сургалтад хамруулж байна. - Цээж ба хэвлийн хөндийн гол судасны мэс заслын чиглэлээр Тайваний үндэсний их сургуулийн эмнэлэгт нэг эмчийг 6 сарын хугацаатай сургасан. ЭМС-ын 2024 оны А273 дугаар тушаалын жагсаалтын А1 дэх жагсаалтад заагдсан Тархи, нугасны гүний төвөгтэй байрлалтай хавдар, хавдар төст эмгэгийн нээлттэй болон тархины дурлангийн мэс заслын технологийг бүрэн нутагшуулах зорилгоор ЭМС-ын санаачлаг, төрийн сангийн сургалтын зардлаар БНТУ-ын КОЧ Анагаах ухааны их сургуулийн эмнэлэг, Американ эмнэлгүүдэд Мэдрэлгийн мэс заслын эмч сувилалгчийн багийг 2 сарын хугацаатай сургалтад хамруулж чадавхижуулсан.
2.3.4.2.	Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн	хамаарахгүй

	сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллах эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сувиллагчийг түлхүү бэлтгэнэ.	
2.3.4.3.	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, алслагдсан орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллыг нэмэгдүүлнэ.	хамаарахгүй

ЗӨВШӨӨРСӨН:
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ

Ц.ТӨМӨР-ОЧИР

ХЯНАСАН:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, ХАМТЫН
АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ

О.БАТГЭРЭЛ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА

Б.АЛЫГРМАА

